

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 06 ДУГААР САРЫН МЭДЭЭ

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Ковид-19 халдвараас сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх чиглэлээр: Эрүүл мэндийн сайдын багцаас аймгийн Нэгдсэн эмнэлэгт Ковид-19 халдварыг шинжлэх 280.0 сая төгрөгийн ПГУ шинжилгээний тоног төхөөрөмж нийлүүлэгдэн, Молекул биологийн лабаротори байгуулаглаа. Эрүүл мэндийн сайдын А/403 дугаар тушаалаар Нэгдсэн эмнэлэгт 4 нэр төрлийн 87430 ширхэг 122.9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн газар 4 нэр төрлийн 17440 ширхэг 24.3 сая төгрөгийн /Ковид-19/-ын халдвараас сэргийлэх хамгаалах хувцас хэрэгсэл нийлүүлэгдлээ.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/263, дугаар захирамжаар Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, Машид-Эрдэнэ ХХК-ийн Цогц төв эмнэлэг, Алтайн хүдэр ХХК, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт Ковид-19 халдварыг эмчлэх ор дэлгэн ажиллуулах, А/296 дугаар захирамжаар АШИУҮИС-ийн дотуур байр, “Эрүүл ирээдүй” мэс заслын эмнэлэгт мэс засал гэмтэл, чих хамар хоолой, амбулаторит ор дэлгэн ажиллуулах, “Энхийн зуун” дотор мэдрэлийн эмнэлэгт Нэгдсэн эмнэлгийн дотор, мэдрэлийн амбулатори болон хэвтүүлэн эмчлэх, яаралтай тусламж, хол ойрын дуудлага, төрөх эмэгтэйчүүд, хүүхэд, халдварт өвчин, нүд, хавдар, сэтгэцийн чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлэхээр тус тус шийдвэрлэлээ. .

Ковидын халдварын 1425 батлагдсан тохиолдол бүртгэгдэж Эрүүл мэндийн сайдын 2021 оны 227 дугаар тушаалын дагуу “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархвар судалгааны хуудас” хөтлөн, тархвар зүйн зураглал гаргалаа.

Батлагдсан тохиолдлын хавьтал 1266 хүний судалгаа гаргаж 6 дахь хоногийн шинжилгээнд 975, 13 дахь хоногийн шинжилгээнд 291 иргэнийг хамрууллаа.

Тайлант хугацаанд PCR 4442, антиген түргэвчилсэн оношлуураар 8422 шинжилгээ хийлээ.

Тус аймагт ковид-19 цар тахлын анхны тохиолдол 04 дүгээр сарын 24-нд бүртгэгдсэнээс хойш 06 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар нийт 1628 хүн өвчилснөөс 2 хүн нас барж, 913 хүн эдгэрэн эмнэлгээс гарч 713 хүн эмчлүүлж байна. Хэвтэн эмчлүүлэгдээс 592 хүн хөнгөн, 87 хүн хүндэвтэр, 26 хүн хүнд, 8 хүн нэн хүнд гэсэн эмнэл зүйн шинж тэмдэгтэй байна.

Ковид-19 цар тахлын халдвараар 0-4 насны 30, 5-9 насны 39, 10-14 насны 66, 15-18 насны 8 нийт 143 хүүхэд өвчилсөн нь нийт өвчлөгсдийн 10 хувийг эзэлж байна. Нийт халдвар авсан 164 хүүхдийн 75 нь эдгэрэн эмнэлгээс гарч, 106 хүүхэд нь эмчлэгдэж байгаа бөгөөд үүний 58 нь гэрээр эмчлэгдэж байна.

Хятад улсын Синофарм үйлдвэрийн “Вероцел” вакцинаас 69978 хүн/тунг татан авч аймгийн хэмжээний 18-аас дээш насны хамрагдвал зохих 37536 хүнээс 1-р тунд 33329 буюу 87.2 хувийг, 2-р тунд 30433 буюу 84.1 хувийг тус тус хамруулаад байна.

Мөн аймгийн хэмжээний 12-17 насны 11428 хүүхэд, 515 жирэмсэн эх, хавдартай 17 хүн нийт 11960 иргэнийг дархлаажуултад хамруулах зорилгоор

Пфайзер-БиоНТех үйлдвэрийн “Комирнэти” (BNT162b2) вакцинаас 3000 хүн/тунг татан авч дархлаажуулалтыг эхлүүллээ.

Аймгийн Засаг даргын 06 дугаар сарын 14-ний өдрийн А/256 дугаар захирамжаар “Алтайн хүдэр” ХХК-ийн хүдрийн уурхайд коронавирусийн тохиолдол бүртгэгдэж “Улаан түвшин”-д шилжсэнтэй холбогдуулан тус газрын үйл ажиллагааг 06 дугаар сарын 14-ний өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд үйл ажиллагааг бүрэн зогсоож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах ажлын хэсгийг байгуулж, тус газарт шуурхай штаб томилон урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг авч ажиллалаа.

Гамшгийн шуурхай удирдлагын газар, Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газар, Ус цаг уур орчны шинжилгээний газраас ирсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээллийг албан бичиг, цахимаар авч сумдын Тамгын газрын дарга, Аймгийн Онцгой комиссын гишүүд, малчид, иргэдэд нийт 1 удаа 4420 иргэнд, коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 удаа, 2460 хүнд багц мессежээр, байгууллагын вэб хуудас, аймгийн 8 фэйсбүүк группээр мэдээллийг байршуулж, “Миний нутаг” телевизээр 2 удаагийн давтамжтайгаар мэдээллийг хүргэн ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Гэр бүлийн хөгжил, хамгаалал”, “Засагт ханы хүүхдүүд”, “Алтайн залуус” арга хэмжээний төсөл, стратеги төлөвлөгөө болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Батлан хамгаалахын сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд нарын аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилт, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд тус тус хяналт-шинжилгээ хийж, санал, зөвлөмжийг хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, гамшгийн сангийн зарцуулалтад хийсэн дотоод аудитын тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээ. Мөн

“Архигүй-Алтайчууд” хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийлээ.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2021 оны хагас жилийн биелэлтэд үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн 06 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар хуралдаанаар хэлэлцүүлээ. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг 76.59 хувийн, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг 72.35 хувийн биелэлттэйгээр Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем /unelgee.gov.mn/-д заалт бүрээр байршуулж, тайланг 06 дугаар сарын 29-ний өдрийн 1/701, 06 дугаар сарын 30-ны өдрийн 1/706 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус хүргүүллээ.

Тайлант хугацаанд Үйлчилгээний нэгдсэн төв нь “Иргэдээ сонсох нээлттэй утас 70481111”, мэдээлэл лавлагааны “E-Mongolia” цахим үйлчилгээ, Улсын бүртгэлийн

хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд нэг цэгээс түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэн ажиллалаа.

Тайлант хугацаанд нийт 13 өргөдөл бичгээр ирснээс 10 өргөдлийг шийдвэрлэж, 3 өргөдөл хяналтын шатандаа, хугацаандаа судлагдаж байна.

Шийдвэрлэлт 76,9%, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног, хугацаа хэтэрсэн өргөдөл гомдол байхгүй.

“Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111” дугаарын утсанд 06 дугаар сарын байдлаар нийт 63 дуудлага хүлээн авснаас, хувийн мэдээллээ бүрэн өгсөн 44 гомдол, санал, хүсэлтийг E-OFFICE программд бүртгэн, холбогдох байгууллагуудад шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Шийдвэрлэж хариу өгсөн 34, хугацаандаа судлагдаж байгаа 10 өргөдөл байна. Шийдвэрлэлт 77,27%, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног байна.

Иргэдийн санал хүсэлтийг агуулгаар нь авч үзвэл хог тээвэрлэлттэй холбоотой хүсэлт 13, цахилгаан эрчим хүчтэй холбоотой гомдол 2, цэвэр, бохир устай холбоотой 4, сум өрхийн эрүүл мэндийн төв, эмч ажиллагсдын ёс зүй, ур чадвар, ковидын нөхцөл байдалтай холбоотой гомдол санал 7, цахилгаан эрчим хүчтэй холбоотой 2, ковидын нөхцөл байдал, ариутгал халдваргүйтгэлийн талаар 4, барилга байгууламж, хот тохижилт, амьдрах орчинтой холбоотой 3, төрийн албан хаагчийн ёс зүйтэй /НДХ/ холбоотой 2 гомдол, бусад асуудлаар 7 өргөдөл гомдол ирснийг холбогдох байгууллагад шилжүүлэн шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллалаа. Хугацаа хэтэрсэн гомдол хүсэлт байхгүй.

E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн цахим системээр нийт 54 нэр төрлийн лавлагаа, мэдээллийг иргэдэд нэг шатлалаар олгож байна.

Тайлант хугацаанд 7 төрлийн цахим мэдээллийн үйлчилгээг 126 иргэнд төлбөртэй, 42 иргэнд төлбөргүй, нийт 168 лавлагаа мэдээлэл гаргаж, 139.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүллээ.

НИЙГМИЙН САЛБАР:

Аймгийн нэгдсэн эмнэлэгт 06 сарын 01-ны өдрөөс 06 сарын 24-ний өдрийн хооронд 3091 ор хоногийг ашигласнаас 54 хүнд өвчтөн байсан ба нас баралтын 5 тохиолдол гарсан байна. Амбулаториар нийт 3576 үйлчлүүлэгч үзүүлснээс томуу, төст өвчинтэй 37 тохиолдол бүртгэгдлээ. Хүүхдийн тасагт 140 ор хоногийг ашигласнаас 1 хүнд хүүхдийг эмчиллээ. Энэ хугацаанд нийт 55 эх эсэн мэнд амаржиж 56 хүүхдийг хүлээн авлаа. Нийт 21 мэс засал хийсэн. Түргэн тусламжийн 232 дуудлагад үйлчиллээ. Яаралтай тусламжийн тасагт 285 хүн өөрөө ирж үзүүлснээс 7 буюу 2.4% нь томуу, томуу төст өвчний тохиолдол байлаа. Алсын дуудлагын 3 тохиолдолд Бугат, Жаргалан, Цогт сумд үйлчиллээ.

Аймгийн хэмжээнд 2021 оны эхний 5 сарын байдлаар 564 эх нярайлж өнгөрсөн оны мөн үеэс 8 тохиолдол буюу 1.4 хувиар, 568 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 9 хүүхдээр буюу 1.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нас баралтын 123 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 13 тохиолдлоор өссөн үзүүлэлтэй байна. Нас баралтын түвшин 1000 хүн амд 2.1 байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн сайдын А/376 дугаар тушаалаар Эрүүл мэндийн газар 37.5 сая төгрөгийн Рено Логан маркийн автомашин нийлүүлэгдлээ.

Тайлант хугацаанд 6 нэгжийн, 11.2 сая төгрөгийг коронавирусийн халдвараас хамгаалах үйл ажиллагаанд зориулан аймгийн онгой комисст хандивласан байна.

Эрүүл мэндийн яаманд короновирусийн эмийн захиалга хүргүүлснээр нийт 14.1 сая төгрөгийн эм татан авч, голомтот бүсүүдэд хуваариллаа.

НҮБ-ын Хүүхдийн сангийн ус хангамж ариун цэвэр эрүүл ахуйн хөтөлбөрийн санхүүжилтээр “Гараа тогтмол угааж Ковид-19 халдвараас сэргийлье” цахим уралдааныг зохион байгуулж эхний шатанд 10 хүүхэд шалгаруулж урамшууллаа.

“Алтай мэдээ” агентлагийн цахим хуудаст 72 төрлийн мэдээ тавьж 11244 хандалт, “Монцамэ” агентлагт 8 төрлийн мэдээ тавьж, 7003 хандалт авлаа.

“Алтай” телевизид 5 удаагийн мэдээ, 2 төрлийн шторик, Алтай радиод 6 удаагийн цаг үеийн мэдээлэл өглөө.

Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газрын пэйж хуудсаар 123 мэдээлэл, эрүүл мэндийн зөвлөгөө, сурталчилгаа тавигдаж 29683 хүн хандалт хийж, 1882 хүн цааш нь түгээсэн байна. Эрүүл Мэндийн Газар Зөвлөгөө” пэйж хуудсанд 20 ширхэг эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмж, мэдээ, мэдээлэл байршуулж 106 хүн хандалт хийсэн байна.

Аймгийн хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн талаарх 2021 оны эхний 5 сарын үзүүлэлтэд дүгнэлт хийн байгууллагын пэйж хуудас, И-оффис програмд иргэд болон бүх байгууллагуудад нээлттэй байршууллаа.

Нийгмийн даатгал: Нийгмийн даатгалын сангаас үйлчилгээ авагч иргэдийн тэтгэврийг 06 дугаар сарын 01-нд багтаан олгож, олгогдоогүй тэтгэвэр тэтгэмжийн өглөггүй ажиллалаа.

Аймгийн хэмжээнд өндөр насны тэтгэвэр авагч 8780 хүнд 3304,5 сая төгрөгийг олголоо. Шинээр тэтгэвэр тогтоолгосон хүсэлт гаргасан сум, аймгийн төвийн өндөр настан 35, тахир дутуу 5, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 2, нийт 42 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмж 34 иргэнд 53888.9 сая, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 24 иргэнд 6.4 сая, оршуулгын тэтгэмж 3 иргэнд 3.0 сая, ажилгүйдлийн тэтгэмж 40 иргэнд 29850.6 сая төгрөгийг тус тус олголоо.

Сайн дурын даатгалд нийт 123 хүн хамрагдсанаас 101 хүн ажилгүй, 0-3 насны хүүхдээ асарч буй 22 эхийг хамрууллаа.

Эрүүл мэндийн даатгалд 963 иргэнийг хамруулж, 58.6 сая төгрөг ЭМД-ын санд хуримтлагдлаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар 132 хүн орж, үүнээс шинээр-8 хүн хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож, 122 хүний групп сунгагдлаа. Цуцлагдсан 2 хүн байна.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой лавлагааг 14 хүнд гаргаж өглөө.

Гэр бүл, хүүхэд, залуучууд: Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн эрх, сурган хүмүүжүүлэх ухааны зарчимд суурилсан хүмүүжлийн эерэг аргын үзэл санааг гэр бүлийн хүрээнд хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар эзэмших, хүүхэдтэйгээ харилцах арга хандлагаа өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх зорилгоор цахим сургалтыг зохион байгуулж, 41 эцэг, эх хамрагдлаа.

“Бид аав ээжээсээ юуг хүсдэг вэ?” эшлэлийн уралдааныг зохион байгуулж 2 насны ангилалд 15 хүүхэд бүтээлээ ирүүлж, эхний 10 хүүхдийг шалгарууллаа.

Иргэдийн санаа бодлыг сонсох, хүүхдэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Хүүхдээ сонсьё” арга хэмжээг цахим хэлбэрээр зохион байгууллаа.

“Нэгдүгээрт хүүхэд үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд хүүхдийн хөгжих хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох, эсэн мэнд амьдрах эрхийг хангахад эцэг эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн эрхийн талаар олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор “Аз жаргалтай гэр бүл” цахим уулзалтыг зохион байгуулж, 3 гэр бүлийг хамрууллаа.

“Халуун сэтгэл-Хайр түгээе” нөлөөллийн аяныг өрнүүлж, 40 хандивлагч оролцон, 2925.0 мянган төгрөгийн хандив цуглуулсныг зорилтот бүлгийн хүүхэд, гэр бүлд хүргэлээ. Мөн аймгийн засаг дарга бүтэн өнчин 50 хүүхдэд тус бүр 100,000 төгрөг олголоо.

Ковид-19 цар тахлын үед зорилтот өрхийн хүүхдүүдийн дархлааг дэмжих, халдвараас сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээний хагас өнчин 146, хөгжлийн бэрхшээлтэй 74, бүтэн өнчин 30, архины хамааралтай гэр бүлд байгаа хүүхэд 50, нийт 193 өрхийн 300 хүүхдэд дархлаа дэмжих витамин, маск, санитас олгож, дархлааг нь дэмжлээ.

Боловсрол, соёл, урлаг: Боловсрол, соёл урлагийн газраас ковид-19 цар тахалтай холбоотойгоор хатуу хөл хорио тогтоосон 14 хоногийн хугацаанд гэр бүлээрээ “Дасгалаар дархлаагаа дэмжье challenge”-ыг зарлан, давхардсан тоогоор 17380 хүн үзэж, 513 хүн бусдад хуваалцаж, 1912 хүн дэмжсэн байна. Шилдэг 6 гэр бүлийг шагнаж урамшууллаа.

Цэцэрлэг, сургууль, дотуур байрын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний болон эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх талаарх мэдлэг, мэдээлэл олгох сургалтад 168 тогооч, нярав, эмч, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс санаачлан зохион байгуулж буй “Хүүхдийн эх хэлний боловсролд эрдэм шинжилгээний хурал”-д 57 албан хаагч, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нэг бүртэй ажиллах аргазүй” сургалтад 300 албан хаагч, төсөлт үйл ажиллагаанд суурилсан аргазүй сэдэвт сургалтад 152 албан хаагч тус тус цахимаар оролцож, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Сургуулийн өмнөх боловсролын багш нарын дунд “Багшаа сонсьё” тайлант хэлэлцүүлгийг онлайнаар зохион байгуулж, 30 цэцэрлэгийн 132 бүлгийн багш, 12

явуулын багш, 10 хөгжмийн багш, нийт 154 багш тайлангаа хамгаалан, ажлын туршлагаа хуваалцаж, санал хүсэлтээ илэрхийллээ.

“Алтайн ЭЕШ-2021” аяны хүрээнд 10 судлагдахууны 24 агуулгыг 54 цагт багтаан давхардсан тоогоор нийт 2800 орчим хүүхдэд цахим давтлагыг зохион байгуулж байна.

Ковид-19 цар тахлын улмаас 11 сумын танхимын давтлага зогссон, өнөөдрийн байдлаар танхимын давтлагад 380 хүүхэд, цахимаар 500 орчим хүүхэд ЭЕШ-д бэлтгэж байна.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээ мэдээлэл: Аймгийн хэмжээнд нийт 486 иргэн ажил хайгч бүртгэлтэй байгаа ба ажлаас чөлөөлөгдөн ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтэй 25 иргэнийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэн тодорхойлолт гарган өглөө.

Ажилтан ажилд авахаар захиалга ирүүлсэн 5 байгууллагын 94 ажлын байрны зарыг олон нийтэд мэдээлсэн ба “Макс Өргөө” ХХК, “Макс Рөүд” ХХК-д ажиллах хүсэлтэй бүртгүүлсэн нийт 23 иргэний ажлын анкетыг холбогдох байгууллагад хүргүүлсэн болно. Аймгийн хэмжээнд хийгдэх бүтээн байгууллалтын ажлын тендерт оролцогч байгууллагуудад дотоодын давуу эрхийн олгох гэрээг 19 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан.

Нийгмийн халамжийн сангийн мэдээлэл: Тайлант хугацаанд цахим эрхийн бичгийн үйлчилгээнд ,670 өрхийн 3409 иргэн хамрагдаж, 41840.0 мянган төгрөгийн санхүүжилт олголоо.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг И-халамж программаар шинэ төрсөн 72 хүүхдийн бүртгэлийг баталгаажууллаа.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Усны тооллого судалгааны ажлыг аймгийн Засаг даргын А/155 дугаар захирамжийн дагуу Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэн, Алтайн өвөр говийн сав газарт хамаарах Цогт, Эрдэнэ, Алтай, Бугат, Цээл сумдын тооллого судалгааны хээрийн ажлыг зохион байгууллаа.

“Алтайн Халиун Буга” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагын Хантайширын нуруунд буга нутагшуулах санаачилгыг дэмжиж нийтдээ 43 бугын илийг нутагшуулсан бөгөөд тайлант хугацаанд төлөвлөгөөний дагуу Төв аймгийн Хустайн нуруунаас 10 толгой бугын илийг авчирч дасган, нутагшуулах хашаанд байршууллаа.

Нөхөн сэргээлт -2024 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар 41.0 хувьтай байгаатай бөгөөд ажил эрчимжүүлэх албан бичгийг сумдад хүргүүллээ. Есөнбулаг сумын нутагт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дагуу олборлолтын үйл ажиллагаа явуулж буй “Болдгянтболд” ХХК-ийн Зүүн сайрын алтны уурхайгаар хууль бусаар ашигт малтмал олборлогчийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон 5,11 га талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэж байна. Мөн газрын доройтол цөлжилтийг сааруулах зорилгоор тус аймгийн Шарга, Тайшир сумын нутагт хууль бусаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас

эвдрэлд орж орхигдсон 30 га газарт нөхөн сэргээлт хийхэд шаардагдах төсвийг 2022 оны улсын төсөвт тусгах саналыг Байгаль орчин аялал жуулчлаын яаманд хүргүүллээ.

Говийн их дархан газрын А хэсгийн менежментийн төлөвлөгөө танилцуулах уулзалтад 1, Төрийн албаны зөвлөл, Архивын ерөнхий газрын хамтарсан “Төрийн албаны тухай хууль болон архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилт” арга зүйн сургалтад 2, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” сэдэвт цахим сургалтад 11, нийт 14 албан хаагч хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР